




БАТЛАВ  
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж.ГАНБОЛД



БАТЛАВ  
HERBALIFE КОМПАНИЙ МОНГОЛ  
ДАХЬ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ  
Г.ДЭНВЭН  
Улаанбаатар хот

**ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2016 оны 05 дугаар сарын 28 өдөр

№ \_\_\_\_\_

Энэхүү гэрээг нэг талаас Нийслэлийн биеийн тамир, спортын газрыг төлөөлж цаашид "А" тал гэх) ахлах мэргэжилтэн А.Болдмаа, нөгөө талаас "Herbalife Mongolia" байгууллагын (цаашид "Б" тал гэх) О. Энхбат нар Улаанбаатар марафон 2016 олон улсын гүйлтийг зохион байгуулахтай холбогдолтой (цаашид гэрээт ажил гэх) харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 124 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 01 сарын 25-ны өдрийн А/51 дүгээр захирамжаар батлагдсан Улаанбаатар Марафон-2016 олон улсын гүйлтийг зохион байгуулахад ивээн тэтгэгчээр хамтран ажиллах.

**Хоёр. Гэрээний хугацаа**

Энэхүү гэрээ нь 2016 оны 05-р сарын 28 өдрөөс 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хүчинтэй үйлчилнэ.  
Гүйцэтгэж байгаа ажил тус бүрийн хугацааг ажил эхлэх бүрд харилцан тохиролцож энэхүү гэрээнд хавсралт болгон мөрдөнө.  
Гэрээт ажил хийгдэж дуусаагүй, гэрээг хаасан акт үйлдээгүй нөхцөлд гэрээ акт үйлдэн хаах хүртэл хүчин төгөлдөр үйлчилж, шууд сунгагдана.

**Гурав. Гэрээний төлбөр**

Улаанбаатар Марафон 2016 олон улсын гүйлтийн тамцээнийг Б тал 10,000,000 (үсгээр: Арван сая төгрөг) төгрөгөөр ивээн тэтгэж олоорцоно.  
А тал нь гэрээний хугацаанд Б талд дараах боломжуудыг олгож хамтран ажиллана.

- Herbalife компани нь Улаанбаатар Марафон 2016 олон улсын гүйлтийн "Шим тэжээлийн түнш" байна.
- Тус арга хэмжээтэй холбоотой бүхий л хэвлэл мэдээллийн арга хэмжээнд Herbalife компанийг шим тэжээлийн түншээр мэдээлэх
- Улаанбаатар Марафон 2016 олон улсын гүйлтийн 10 км-ийн зайн уралдааныг Herbalife компанийн нэрэмжит уралдаанаар зарлана.
- А талаас эрхлэн гаргасан анонс, зурагт хуудас, хэвлэлийн мэдээ, телевизийн шторк, реклам, тамирчдын энгэрийн дугаар болон бусад зар сурталчилгааны материалууд дээр Herbalife компаний логоо байршуулах
- Тус гүйлтийн арга хэмжээнд өөрийн байгууллагын төлөөлүүлэн 500 хүн гүйлтэд оролцуулах
- Гүйлтийн зам дагуух нийт 2 усны цэгийг Herbalife брэндээр чимэглэх, холын зайд гүйгчдийн эрч хүчийг нөхөх зорилгоор уургаар баяжуулсан бүтээгдэхүүний дээжээс хүргэх

- Чингисийн талбайд өөрийн брэндийн чимэглэлтэй майхан байрлуулж компанийн танилцуулга, сурталчилгаа зохион байгуулах
  - Гүйлтийн зам дагуу, болон марафоны талаарх зурагт хуудас, гүйлтэд оролцогчдын энгэрийн дугаар болон холбогдолтой бусад материалд өөрийн байгууллагын логог оролцуулах
  - Тус гүйлттэй холбоотой зохион байгуулагдах олон нийтийн хэвлэл мэдээллийн оролцоотой бүхий л арга хэмжээнд өөрийн байгууллагын төлөөллийг “Шим Тэжээлийн Түнш”-р оролцуулах
  - Арга хэмжээний нээлт, шагнал гардуулах ёслол болон хаалтын үйл ажиллагаанд өөрийн компанийн төлөөллийг оролцуулах
  - Нийт гүйлтэд оролцогчдын бие халаалтыг өөрийн компанийн хамтран ажилладаг мэргэжлийн тамирчдын туслалцаатайгаар хийлгэх
- 13 Гэрээт ажил дууссаны дараа талууд хоёр талаасаа хийгдсэн ажлуудыг дүгнэж, тооцоо нийлж ажиллана.
- 14 Б тал ивээн тэтгэлэгийн төлбөр 10,000,000 төгрөгийг энэхүү гэрээнд гарын үсэг зурсны дараа бэлнээр А талд төлнө. Ивээн тэтгэлэгтэй холбоотой бүхий л татвар хураамжийг А тал хариуцна.

**Дөрөв. Талуудын үүрэг хариуцлага**

- 1 Гэрээт ажлын явцад талууд мэдээлэл солилцох, ажил хянах, батлах бүхий л ажилд урьдчилсан бэлтгэлтэй, хамтран ажиллана.
- 2 Гэрээний үүргээ билүүлээгүй, талууд эрхээ эдлэх боломж олдоогүйгээс гарсан цаг хугацааны хоцролт, мөнгөн алдагдалыг буруутай тал нөхөн төлнө.
- 3 Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд гэрээ дууссан актыг Б тал үйлдэж, А тал баталж гэрээг хаана.
- 4 Талууд гэрээнд болон гэрээний хавсралтанд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд ажлын 5 өдрийн өмнө нөгөө талдаа мэдэгдэж, шийдвэрлүүлнэ.

Талууд үүссэн ямар нэг нөхцөл байдлыг гэрээний заалтаар шийдвэрлэж байхад хурвэл харилцан зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд энэ зөвшилцөлийг гэрээ байгуулсан этгээдүүд өөрийн биеэр хийж, гарын үсэг зурсан байна.

**Гэрээ байгуулсан талуудын төлөөлөл**

“А” ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ  
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР,  
СОРТЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН  
А.БОЛДМАА

“Б” ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ  
БРЕЙКТРҮҮ ПИ АР ХХК-ИЙН  
МЕНЕЖЕР  
О.ЭНХБАТ



**Хялагчийн хаяг:**  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын төв өргөө, Төрийн Театрын музей, 3-н саяд, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар Утас: +976-11-328977, 9917-8373

**Гүйцэтгэгч хаяг:**  
DB Building, 403 тоот, Олимпийн гудамж 12-1, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: 70004377, 99096025